

Хархорин хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын протокол

Хархорин ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 03 дугаар сарын 28 ны 14 цаг 00 минутад Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэ толгой баг, Усжуулах 00 хаягаар байрлах Хархорин ХК-ийн хурлын танхимд эхлэв.

Хуралд байлцсан: Хувьцаа эзэмшигчид

1. П. Халиун- /377,660 ш хувьцаа эзэмшигч С.Пүрэвийг итгэмжлэлээр төлөөлж оролцов/.
2. Ц. Баасансүрэн-Хувьцаа эзэмшигч /100/
3. Л. Батжаргал-Хувьцаа эзэмшигч /93/
4. С. Дэжээхүү-Хувьцаа эзэмшигч /73/
5. Г. Бямба- Хувьцаа эзэмшигч /280/
6. Л. Хосбаяр- Хувьцаа эзэмшигч /28231/
7. Ч. Отгонбаяр- Хувьцаа эзэмшигч /100/
8. Н. Рагчаа- Хувьцаа эзэмшигч /100/
9. Ц. Бүрэнжаргал- Хувьцаа эзэмшигч /100/
10. Ч. Отгонсүрэн- Хувьцаа эзэмшигч /93/
11. Д. Дашмаа- Ерөнхий нягтлан бодогч, Хувьцаа эзэмшигч /100/

Бусад гишүүд

1. П.Бишрэл-ТУЗ-ийн дарга
2. Б.Бүрэн-ТУЗ-ийн хараат бус гишүүн
3. Д.Баярмаа-ТУЗ-ийн хараат бус гишүүн
4. Г.Бямбаа-ТУЗ-ийн хараат бус гишүүн
5. П. Учрал-Гүйцэтгэх захирал
6. Р. Отгонбаяр- Ерөнхий менежер
7. Б. Ганбат –Хурал зохион байгуулах комисс
8. Д.Энхбаяр-Тооллогын комисс
9. С.Амгалан-ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч
10. Л.Бямбасүрэн-Ерөнхий агрономич
11. Ц.Болортуяа-Тооллогын комисс болон компанийн бусад ажилтан ажиллагсад оролцсон болно.

Хурлын дарга П.Бишрэл: Эрхэм хүндэт та бүхэнд энэ өдрийн амар амгаланг эрин мэндчилье. Энэхүү хуралд хүрэлцэн ирсэн нийт ХЭ та бүхэнд хуралдаа идвэхитэй оролцох байх гэж бодож байна.

Б.Ганбат: Сайн байцгаана уу. Хархорин ХК-ийн 2015 оны хувьцаа эзэмшигчидийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд энэ өдрийн мэндийг айлтгая. Тооллогын комиссоос хурлын ирцийн дүнг танилцууллаа. Өнөөдрийн хуралд нийтдээ 539515 ш хувьцаа эзэмшиж байгаа нийт 575 хувьцаа эзэмшигч ирэхээс 406930 хувьцаа эзэмшиж байгаа 11 хувьцаа эзэмшигч ирсэн байна. Компаний нийт хувьцааны 75%-аар ирц бүрдсэн гэж үзэж байна. Иймд компаний тухай хууль болон компаний дүрмийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөр гэж үзэхэд хангалттай байна. Хурлыг даргалж байгаа ТУЗ-ийн дарга П. Бишрэл захирал хурлыг нээж үг хэлнэ үү.

П.Учрал: 75 %-ийн ирц бүрдсэн байна 70 %-ийн хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн талаар, итгэмжлэлийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулна уу. 70%-ийн хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч ирсэнээр хурал хүчин төгөлдөр болж байна. Хурал хэдэн хувьтай байж хүчин төгөлдөр болох вэ? (итгэмжлэлийг хуралд оролцогсдод танилцуулав)

Б.Ганбат: Өнөөдөр хувьцаа эзэмшигч Сүрэнжав овогтой Пүрэвийг төлөөлж түүний төрсөн охин болох Пүрэв овогтой Халиун итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хүрэлцэн ирсэн байна. Нотариатаар 2015.03.25-ны өдөр баталгаажуулсан итгэмжлэл байна. Та бүхэн танилцана уу. Хуулийнхаа дагуу хурал хүчин төгөлдөр болоход 50%-аас дээш хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирсэн байх ёстой.

П.Бишрэл: 2015 оны Хархорин ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Хурлаар хэлэлцэх асуудлуудыг Б.Ганбат танилцуулна уу.

Б.Ганбат: Өнөөдрийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэхээр ТУЗ-өөс тогтоол гарсан байна.

Хэлэлцэх асуудлууд:

1. Компаны 2014 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн тухай ТУЗ-ийн дүгнэлтийг уншиж танилцуулаад, дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг хэлэлцэж батлах шаардлагатай байгаа
3. ТУЗ-д гишүүдийг шинээр сонгож томилох
4. Компаний 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах
5. Их хэмжээний хэлцэл хийх тухай ТУЗ-ийн шийдвэрийг батлах дараалалтай байна.

Хурлын дэгийг танилцуулья.

1. Хурлын ирц бүртгэх
2. Хурлын ирцийг мэдээлэх /тооллогын комиссоос мэдээлсэн/
3. Хурлын дарга хурлыг нээж хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах
4. Хурлаар хэлэлцэх асуудлуудийг нэг бүрчлэн та бүхэнд уншиж, ерөнхийд нь танилцуулах ажиллагаа явагдана. Асуудлуудыг танилцуулсаны дараагаар хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд чөлөөтэй асуулт хариулт, санал шүүмжлэлээ чөлөөтэй илэрхийлж болно.

5. Санал хураалт явагдана. /Санал хураалтыг саналын хуудсаар авна. Саналын хуудсыг тооллогын комисс тарааж өгөөд саналын хуудсыг хэрхэн яаж бөглөх ямар тохиолдолд хүчин төгөлдөрт тооцох талаар зааварчилгаа өгөн та бүхнээс санал авах байгаа./
6. Санал хураалтаа өгсөний дараа тооллогын комисс-д саналын хуудсаа хүлээлгэж өгсөнийг тооллогын комисс бүртгэж аваад тооллогын дүнг гаргаж байх хооронд хурал 15 мин завсарлана.
7. Тооллогын комисс тооллогын дүнг хурлын дарга болон хувьцаа эзэмшигчидэд танилцуулна.

Б.Ганбат: Хурлыг ойролцоогоор 2 цаг 20 мин-д багтааж хуралдуулна. Компаний 2014 оны жилийн үйл ажиллагааны тайланг Ерөнхий агрономч Л.Бямбасүрэн танилцуулна.

Ерөнхий агрономч Л.Бямбасүрэн Компаний 2014 оны жилийн үйл ажиллагааны тайланг танилцуулав (тайланг хавсаргасан байгаа)

Ерөнхий агрономч Л.Бямбасүрэнгээс ТУЗ-ийн гишүүдийн асуусан асуултууд:

С.Бүрэн: Суулгацыг гадагш нийлүүлнэ гэхээр хаана хаана нийлүүлэх вэ?

Л.Хосбаяр: Дотоодын зах зээлтэй юм уу? Хэдэн жилийн дараа ургацаа өгөх вэ?

Д.Баярмаа: Оросоос ирсэн суулгацыг тариалаад хэр хэмжээний ургац авсан бэ? Борлуулалт хийхэд хүндрэлтэй байдаг гэж байна ямар ямар асуудлуудтай тулгардаг вэ?

Баярмаа: Хаврийн тариалалт эхлэхэд зэрлэг, хог ургамал талбайд хэр хэмжээтэй ургадаг, тэрэнд зарцуулагдах хүн хүчний тоо, багаж хэрэгслийн тоо, үүнээс урьдчилан сэргийлэхэд ямар арга хэрэглэж байна вэ? Хадаж байгаа юм уу түүж байгаа юм уу? Үндсийг авч устгаж байна уу? Хог ургамал дээр химийн бодис ашигладаг уу? Ямар бордоо хэрэглэдэг вэ? Орон нутгийн чанартай юм уу? Нүүрийн лаг шаврыг бордоонд ашигладаг гэсэн тэгэхээр Хархорины сувгийн лаг шавруудыг бордоонд ашиглаж болох уу? Бүүц ашиглахдаа ямар төрлийн бүүц ашигладаг вэ? Үртэс хар шороо хоёрыг холиод мод тарьдаг ш дээ шүлтлэг чанар нь чацарганд хэрэглэхэд өндөр гарах уу ямар байх бол? Шилмүүст модонд ашиглахад муу гэдэг ш дээ.

Хариулт:

П.Учрал: Бямбаа аграа би тайлбарлая. ТУЗ-ийн гишүүдэд хэлэхэд мод гэдэг тариалж байгаа жимсээ өгдөггүй ирэх жилүүдээс нь ургацаа өгдөг ба доод талийн хугацаа 3 жил байдаг. Тэгээд үүнийг нутагшуулна гэж байдаг, шууд тариалаад маргааш нь үржүүлээд цааш нь нийлүүлж болдоггүй. Тухайн нутгийн хөрс, уур амьсгалд нийцэн ургаж болж байна, тэгээд энэ модноос гарах үржил шим яг энэ стандартанд хүрч байна уу хүрэхгүй байна энэ нутагт нутагшуулахад ямар өөрчлөлт гарч байгааг тодорхойлж гаргасны дараа цааш нь үржүүлгэ хийн нийлүүлэх ажилд ордог учраас мод тарих нь ихээхэн хугацаа авдаг асуудалтай юм. Тэгэхээр өнгөрсөн жил бид тариалсан гэхээр дөнгөж 1 зуныг үзсэн байна энэ зун үзнэ, ирэх зун ахиад нэг үзнэ тэрний дараагийн зунаас үр дүн гардаг байгаа тэгээд амьдарснаас үржүүлгэ хийх боломжтой болно. Энэ бол дахиад нутагшуулах аргачлал юм. Үргэлжлүүлээд хүлэмжинд тариад хүлэмжнээс бойжуулгын талбай, бойжуулгын талбайгаас талбай дээр гаран 3 үе дамжин амьдралтын хувийг 90 хувиас дээш гэж үзсэн байгаа.

Борлуулалт хийхэд хүндрэлтэй асуудлууд байгаа, 2008 онд хийгдсэн МУ-ын ЗГ-аас баталсан чацаргана хөтөлбөрийн хүрээнд 20000 га талбайг чацаргана тариална гэсэн энэ хөтөлбөр зогсонги

байдалд орсон байна. Өнөөдрийн байдлаар манай компаниас авсан нийт модны нийлүүлэлтийн тоо ХАА-н яамнаас өгч байгаа тоо 4000 га гэж байгаа боловч бидний тооцоолсоноор 1000 га талбайд л тариалагдсан байгаа. Тэгэхээр 20000 га талбайд хийгдэх тариалалт байхгүй, энд юу дутагдаад байна гэвэл мэдээлэл дутагдаад байгаа юм. Хөдөө орон нутгийн хүмүүс ямар шугамаар яаж худалдаж авах мэдээлэл байдаггүй учир ХАА-н яаманд ажлаа хийхгүй байгаа талаар удаа дараа анхааруулга хүргэсэн байгаа. Бид 20000 га талбайд чацаргана суулгац нийлүүлнэ гэж тариалсан чацаргана суулгацыг худалдаж авах газар байхгүй болчихоод байгаа юм. ХАА-н яамтай л ярих хэрэгтэй байгаа юм.

Хог ургамал дээр maschino гээд италийн Инсада-гаас 3-н машин авсан. Тэрний өргөний авцууд өөр өөр байдаг. Эхний авсан 2 tigre нь анх тариалсан талбайд гэдэг зориулалтаар авцын өргөн нь томыг авсан. Мод ургаад эхлэхээр мөр хоорондох зай багасдаг болохоор тэр талбайгаар том техник, тоног төхөөрөмж оруулна гэхээр мод гэмтэх магадлал өндөр учраас ХАА-н яаманд ахин захиалсан 170 м, 190 м авцын өргөнтэй төхөөрөмж ирэх жилийн төлөвлөгөөнд тусгагдсан байгаа. ХАА-н яамтай ярилцаад ТЭД Сан-д гарын үсэг зурах дутуу байгаа. Урьдчилгаа мөнгө өгөх асуудал дээр ярилцаж байгаа. Манай компанид байгаа хуучин техник төхөөрөмж болох ЮМЗ трактор маань эргэлтийн хүч нь хүрэхгүй учраас 210 морины хүчтэй 1 тракторыг авах, ахиад 150 морины 2 трактор авах шаардлагатай байгаа. Энэ нь тухайн хэрэглэж байгаа тоног төхөөрөмжинд эргэлтийн хүчинд тохирч байгаа учраас үр дүнтэй байгаа юм. ЮМЗ тракторт төхөөрөмжөө залгаад явахаар эргэлтийн хүчийг дийлэхгүй өдөрт авах талбай маш бага байгаа. Тоног төхөөрөмжийг тохирох тракторд холбоод явах юм бол цагт 10км/ц явах юм, бид өдөрт дөнгөж 2.3 км газрын зэрлэг ургамал, сэжмийг устгаж байгаа тул техник тоног төхөөрөмжинд баазын шинэчлэлт хийх шаардлагатай байгаа ба энэ нь ирэх жилийн төлөвлөгөөнд тусгагдсан байгаа.

Бид органик бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг учир химийн гаралтай бодис оруулахыг хориглодог. Бид Японы талаас зөвлөмж аваад зөвлөх үйлчилгээ үзүүлж байхад каратэл, бесцис 2-ийг олон улсын хэмжээнд хүнсний бүтээгдэхүүнд хэрэглэхийг зөвшөөрсөн хүнд аюулгүй гэдгийг тодорхойлсон болохоор бид талбай дээр хэрэглэж болно гэж үзэж байгаа.

Сувгийн лаг шавар нь угаагдсан хөрс. Харин нуурын доорх хөрс нь тогтмол, сувгийн доорх лаг шавар нь угаагдсан хөрс гэдэг үүднээс ашиглагдах боломжгүй.

Үртсэн дээр нэмж хэлэхэд бид жимс хураалт хийхдээ мөчрөөр нь хайчилж байгаа тэгэхээр маш их мөчрийн нөөц гарч ирдэг. Тэрийг мөчрийг бутлаад талбай руу чийлшилтийг хамгаалж хийе гээд туршилт явуулж байгаа. Арай том томоор бутлаад байгаа тэгэхээр болох юм байна гэдгийг Л.Бямбасүрэн хоёулаа үзсэн байгаа. Дахиад нөгөө техникийн маань хүчин чадал арай хүрэлцэхгүй ЮМЗ арай багадаад байна, шинэ техник ирэхээр мод бутлагчаа ахиад зүүж үзээд ямар хүчин чадлаар яаж бутлахыг харах боломжтой байгаа.

Л.Бямбасүрэн: Тийм дотоодын зах зээлд аж ахуй нэгж, хувь хүмүүс суулгац захиалсан тохиолдолд тээвэрлэлтийн зардлыг хариуцан хүргэж өгөн тарих, арчлах талаар зөвлөгөө өгдөг байгаа. Аймаг, сүмийн үзэсгэлэн худалдаанд байршуулдаг 100% борлогддоггүй болохоор зөвхөн гэрээ байгуулсан, захиалсан тохиолдолд л гаргаж нийлүүлдэг байгаа.

2014 онд шинээр тариалсан болохоор зөвхөн жимс үзэгдэж байгаа. Тухайлбал алим 3-5 жилийн дараа ургац өгч эхэлнэ, бөөрөлзгөнө, гүзээлзгэнэ тухайн жилдээ ургац өгөх магадлалтай 2-3 жилийн дараа жигд ургац өгч эхэлнэ, далайн хальс 3 дах жилээсээ ургац өгдөг.

Мөндрөөс хамгаалахын тулд мөндрийн “Хурийн шим” компанитай тохиролцон ажиллах шаардлагатай байгаа, маш их өндөр үнэтэй байгаа. Үүл бүүдаж сарниулдаг байгаа. 2-3 удаа боловсруулалтыг тигре төхөөрөмжийн тусламжтай хийж байгаа, ургамал хоорондын боловсруулалтыг цэцэрлэгчдийн хүчээр гар аргаар хийж байгаа. Хүрз болон зээтүүгээр цавчиж л устгаж байгаа. Үрээр үрждэг ургамал үндсээр үржихгүй тул газрын дээд массыг устгаж байгаа.

Ямар ч төрлийн гербицидийг чацарганы талбайд ашиглахгүй, ашиглах боломжгүй юм. Модыг үхжүүлэх болохоор хэрэглэх боломж байхгүй. Хортон шавьжны хэмжээнээс шалтгаалан бесцисийг тодорхой хэмжээгээр ашигладаг, үүнийг жил болгон хэрэглэдэггүй. Зарим үед жилд 2 удаа хэрэглэж магадгүй, хортон шавьжгүй үед 5 жил хэрэглэгдэхгүй байх магадлалтай. Бертройд нэгдлийн хорнууд хэрэглэнэ гэсэн үг. Хор ч биш л дээ ургамлын ханднууд гэсэн үг. Бүх ургамал тодорхой хэмжээний хор агуулж байдаг тэдгээр хорыг нь ялгаж аваад хандлаад хуурай болон шингэн хэлбэрт оруулсаныг Бертройд нэгдлийн хор гэж байгаа.

Талбайд бид орон нутгийн чанартай буюу бууц л хэрэглэж байгаа, бойжуулгын талбайд тодорхой хэмжээний сангас хэрэглэж байгаа. Химийн бордоо улсын хэмжээгээр олдоц ховор үнэ өндөр болсон тэгээд хэрэглэх шаардлагагүй байгаа. 1 га талбайд тариалсан чацаргана маань өөрөө тухайн га талбайдаа 265кг азотын бордоотой тэнцэх хэмжээний азотыг байнга хүримтлүүлдэг байгаа. Энэ ургамал маань хөрсний агаараас азотыг ялгаж авдаг онцлогтой ургамал юм. Дутагталтай тал нь фосфор болон калийн бордоо дутагдах магадлалтай, үүнд бид хөрсний шинжилгээ хийж байгаад хэрвээ дутагдсан байвал фосфо бактерийн болон калийн мегатирум гэсэн органик бордоогоор буюу бактерийн амьд бордоогоор бордох төлөвлөгөөтэй байгаа.

Сүвгийн лаг шавар бол бордоонд ашиглахад маш их хүндрэлтэй. Нэгдүгээрт тээвэрлэлтээс авахуулаад шфроог шороон дээр зөөж байгаа нь эдийн засгийн талаасаа бэрхшээлтэй мөн агроүйлдвэрлэлд ашиглахад лаг шавар маань хөрсний бүтэцгүй болсон хөрс тэгээд элс гэсэн үг. Тэгэхээр үржил шимийн хувьд тийм ч сайн биш гэсэн үг. Хуучин хөх бууц ашигладаг.

Ер нь чацаргана гэхгүй үртсийг бол дандаа өнжөөсөн, хамгийн багадаа 3-4 жил өнжөөсөн үртсийг ашигладаг энэ нь бүрэн ялзарсан гэсэн үг. Яагаад гэвэл үртэс маань модны хэсэг, модны хэсэг нь давирхайтай, давирхай задрахаараа шүлтлэг чанар нь өсдөг. Чацаргана дээр болон модлог ургамал дээр үртэс ашиглахад бэрхшээлтэй байгаа. Тийм. Ер нь ихэнх модлог ургамлын хөрсний PH нь 6-аас 6.5 тай саармаг хөрсөнд ургаж байгаа. Шүлтлэг хөрс гэдэг маань намаг гэсэн үг. Намагт бол намгийн доод ургамлууд ургадаг, хүчиллэг гэх юм бол хүчиртай хөрс болно. Хүчиртай хөрсөнд ашиг шим багатай ургамлууд ургадаг.

Б.Ганбат: Санхүүгийн тайланг Ерөнхий нягтлан Д.Дашмаа танилцуулна.

(Компанийн 2014 оны санхүүгийн тайлангийн тухай ТУЗ-ийн дүгнэлтийг ерөнхий нягтлан бодогч Д.Дашмаа уншиж танилцуулав, дүгнэлтийг хавсаргасан байгаа болно)

Санхүүгийн тайланшийн тухай асуулт:

С.Амгалан: 2014 онд 110 сая ₮-ийн алдагдалтай ажилласан юм үү? 2013 онд ямар байсан бэ? Бас алдагдалтай ажилласан юм үү? Алдагдал багасаж байгаа юм үү? Уучлаарай харьцуулж харахад өөрийн саналаа хэлэхэд өнгөрсөн онтойгоо харьцуулсан текстээ арай бага графикаар харуулсан юм байхгүй болохоор ойлгоход жаахан бэрх байна. Санхүүгийн тайлангийн хувьд болохоор миний ойлгож байгаагаар хувьцаа эзэмшигчдийн хувьд хэдхэн асуудал л чухал ш дээ. Тэгэхээр жижиг

зардлууд яахав угаасаа үйл ажиллагаанд тодорхой байдаг. Борлуулж байгаа марж нь нэмэгдэж байгаа юм уу, өртөг багасаж байгаа юм уу тиймэрхүү асуудалдаа гол нь он оноор харьцуулсан график байгуулвал арай дээр юм болов уу гэж бодсон юм. Яагаад 110 сая ₮-ийн алдагдалтай ажилласан юм бэ? Мөндрөөс болсон юм уу? Энэ олон төслийн санхүүжилтийн зээлийн дундаж хүү гэж байгаа биз дээ? Одоо байгаа склад ямар хэмжээтэй байгаа вэ?

Баярмаа: Бүтээгдэхүүн болгож гаргах ажлыг ирэх жилээс эхлэж хийнэ гэсэн үг үү? Увсад жижиг жижиг савласан чацарганы бренд байгаатай ижил Хархоринд бренд бүтээгдэхүүнтэй болно гэж ойлгож болох үү? Боловсруулах үйлдвэр ойрийн хугацаанд гэхээр яг хэдий үед баригдах вэ?

Д.Дашмаа: Тийм 2013 онд 157 сая ₮-ийн алдагдалтай ажилласан. Тийм алдагдал багасаж байгаа

Б.Ганбат: Нэмж хэлэхэд компани 2014 онд 110 сая ₮-ийн алдагдалтай ажилласан тул Нэмж хэлэхэд компани 2014 онд 110 сая ₮-ийн алдагдалтай ажилласан тул Нэмж хэлэхэд компани 2014 онд 110 сая ₮-ийн алдагдалтай ажилласантай холбоотойгоор 2014.02.26 өдрөөр ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан байгаа. Компаний тухай хуулийн дагуу ТУЗ нь санхүүгийн жил дүүссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашгийн талаар шийдвэр гаргасан байх ёстой.

П.Учрал: Яагаад тухайн компани маань алдагдалтай ажиллаад байна вэ гэвэл ашигтаа хүрэх хэмжээний ургац авч чадахгүй байна. Үүн дээр дутагдалтай асуудлууд байна. Усалгааны систем тавих заавал шаардлагатай ургацыг тогтворжуулахын тулд, хоёрт ургасан ургацаа хурааж авах сав баглаа байхгүй байна. Бид өнгөрсөн жил яаран яаран 50 сая ₮-өөр шахан шахан дахиад нэг склад барьсан. Складтай болсоны хүчинд тодорхой хэмжээний ургац авч чадсан. Одоо та бүхэнд процессуудтай нь танилцуулна. Бид сайлаа бэлдэхээр саваа бэлд гэж савгүй байж баахан саалтай болчихоод тэрийгээ авч чадаагүй тодорхой хэмжээний ургац талбайд нь үлдээсэн байгаа. Тэгэхээр энэ жилийн төлөвлөгөөнд бид усалгааны системийг сайжруулах, техникийн баазыг шинэчлэх, склад савыг бэлдэх байгаа. Бидний тарьсан ургац ирэх жил болгон нэмэгдэх функцтэй байгаа тэгэхээр энэ дээр бид дараа дараагийн сав баглааг бэлдэж, хадгалах агуулах бэлдэхгүй бол ургац хичнээн модон дээр байлаа гээд бид ургацаа хадгалж чадахгүй бол авах боломжгүй болоод байна. Урьд жилийн алдагдал гэдэг бол өртгөө нөхөх хэмжээний ургацыг авч чадахгүй байна гэсэн үг юм. Ирэх жилд тавьж байгаа зорилго бол ирэх жилийн өртгийг өөрийнхөө орлогоороо нөхөж балансыг 0 0 болгох, дараагийн жилээс нь бид ашигтай ажиллаж эхлэх, энэ хугацаа өнгөрсний дараа цэвэр ашиг руу орох байгаа. Та бүхэнд хандаж хэлэхэд бид банкинд 80 сая ₮-ийн өртэй байж хувь компани болон хувь хүмүүст их өртэй байгаа. Энэ дотроос нь харахад дандаа манай гэр бүлийн хүмүүс байгаа. Хувь хүмүүст өрөө төлөхөд хүү бодогдохгүй, харин "Гангар Инвест" ХХК-ийн хувьд хүү тооцогдож байгаа. Яагаад гэвэл тухайн компани маань бидэнд оруулж байгаа санхүүжилтийг өөрийнхөө хөрөнгийг барьцаалаад авсан зээлээсээ өгч байгаа учраас тухайн компанийн авч байгаа зээлийн хүүний хэмжээг бид буцааж төлөх үүрэг хариуцлага хүлээсэн. Хувь хүмүүст ч гэсэн хүү төлөх нь зөв байх гэсэн зарчмыг баримталж байгаа. Банкнаас авч байгаа зээлийнхээ хэмжээнд яг хүүгийнхээ хэмжээгээр буцааж хувь хүмүүсд мөнгийг нь буцааж өгөх нь зөв байх гэсэн бодолтой байгаа. Хэрвээ яг хувиараа явах юм бол 70%, 30% болсон гэх юм бол бусад хувь эзэмшигчид ч гэсэн энэ хэмжээний хариуцлагыг хүлээх ёстой. Тэгэхээр энийгээ компани өөрөө үүрэх ёстой юм уу гэсэн асуудал байгаа. Компаний ирээдүй бол ирэх жилийг бид давж чадах юм бол 2017 оноос хөрөнгө оруулалтынхаа нөхөн төлөлтөнд орох боломжтой. Тухайн жилийнхээ урсгал зардлыг өөрөө даах чадвартай болох байгаа. Бидний урд жилүүдийн алдагдал бол өндөр байсан одоо багасч байгаа ирэх жилээс ашиг алдагдлийн тэнцлийг тэглэнэ гэх зорилготой. Хархорин ХК-ийн урсгал зардал цалинтайгаа жилдээ 1

тэрбум ₮ байдаг. Энэ зардлыг нөхөхийн тулд бид 300 тн жимс авч хаах боломжтой. 300тн жимсийг 3300-гаар зарлаа гэхэд 990000 сая ₮ болох юм. Тиймээс 300тн-оос доошгүй жимс авах зорилготой сав баглаагаа бэлдэх хэрэгтэй байгаа юм. Одоо бидний байгаа хүчин чадал өнгөрсөн жил 80-90 тн жимс авлаа. Сүүлд барахаа болиод ирэхдээ нэмж сав буюу жижиг хөлдөөгчөө нэмж барьсан. Ирэх жилийн төлөвлөгөөнд 400 сая ₮ -ийн хөлдөөх камер нэмж барихаар тусгасан. Склад гэхээр юм байхгүй хөргөгч тавиад тойруулаад сэндвичээр боосон жижиг агуулах байгаа. Хүчин чадал нь 10тн-ийг хийж болох уу? Ургац авах хугацаа 2 сар л байна. Тэгэхээр энэ хугацаанд жимс авахдаа хөлдөөгчийн багтаамжаар тодорхойлохоос биш жимсний гарцаараа тодорхойлох боломжгүй. Жимсний гарц хангалттай байгаа. Одоо та бүхэн талбайд очиж үзэхэд жимстэй мод байгаа. Одоо бүх зүйлийн үнэ өсч байна тиймээс бид ирээдүйд үйлдвэрлэлийг оруулж ирэх хэрэгтэй, түүхий эдээ хагас боловсруулсан бүтээгдэхүүн болгож зарвал илүү үр өгөөжтэй гэсэн дүгнэлтийг гаргаж байгаа. Энэ дээр тусад нь хөрөнгө оруулалтын өөр шийдлүүдийг ярилцаж байгаа.

Тийм ирэх жилээс эхлэнэ. Энийг оруулахын тулд ахиад 1 сая долларын хөрөнгө оруулалт хэрэгтэй. Ерөнхийдөө 3 тэрбум ₮-нд гайгүй үйлдвэр баригдана гэж үзэж байгаа. Одоо жимсээ 3300 ₮-өөр жимсээ зарж байгаа бол үйлдвэрийнхээ өртгийг хаагаад 3 дахин нугалах боломжтой. Тэгэхээр ирээдүйд боловсруулах үйлдвэрийг ойрийн хугацаан барих хэрэгтэй байгаа. Энэ жилийн төлөвлөгөөнд байгаа. Учрал, Бишрэл, Гангар инвест ХХК-ийн бизнес хөгжил эрхэлсэн захирал О.Төмөрбаатар, Л. Хосбаяр, Гангар инвест ХХК-ийн ерөнхий захирал Ж.Энхтөр, Гангар инвест ХХК-ийн үйл ажиллагаа эрхэлсэн захирал ЭнхАмгалан нар ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшсэн байгаа. Хуулийн дагуу 3-аас доошгүй хараат бус гишүүн байх ёстой, өнөөдөр Баярмаа, С. Амгалан, Бүрэн нэр дэвшсэн.

Л.Бямбасүрэн: 10тн багтахгүй

ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх, томилох

Б.Ганбат: Бид өнөөдрийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийг шинээр томилох шаардагатай байгаа. Яагаад сонгох шаардлага гарсан болохыг тайлбарлая. Одооны ТУЗ 2013 оны хурлаар сонгогдсон байгаа. Компаний дүрэмд зааснаар ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар 4 жилийн хугацаатай сонгож ажиллуулна гэж заасан байдаг. Дараагийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох болоогүй байгаа тэгэхдээ ТУЗ-ийн аль нэг гишүүн нь ТУЗ-өөс гарах хүсэлтээ өгсөн тохиолдолд бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулж ахин шинээр томилдог. Өнөөдөр Г.Бямбаа гишүүн нь хараат бус гишүүн, компанид харуул хамгаалалтын ахлахын ажилд орсон байгаа. Энэ шалтгаанаас хамааран ТУЗ-ийн хараат бус гишүүнээс чөлөөлөгдөх өргөдөл гаргасан. ТУЗ-ийг өнөөдөр огцруулаад шинээр сонгох асуудлыг хэлэлцэж батлах байгаа. Өнөөдрийн хурлаар шинээр сонгогдох гишүүдийг танилцуулая. Ердийн гишүүн 6 хүн байх ёстой.

П.Учрал: Ашиг сонирхлын зөрчил үүссэн. Хараат бус биш гэсэн үг тухайн байгууллагаас НД-ын шимтгэлээ төлүүлж байгаа тохиолдолд ТУЗ-ийн хараат бус гишүүн гэх статусд нийцэхгүй байгаа юм.

Компанийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг эдийн засагч Бат-Орших уншиж танилцуулав (Төлөвлөгөөг хавсаргасан байгаа болно)

Үйл ажиллагааны төлөвлөгөө асуулт:

С. Амгалан: Тооцоолсон чацаргана жимс зарах 3200₮ хэлбэлзэлтэй үнэ үү? Урд хугацааны гэрээ байгаа юу? Дараа нь төлөвлөгөөний танилцуулгаа хийхдээ зүгээр excel программ дээр тоо тавихаасаа илүүтэй график ашиглаарай.

Л. Хосбаяр: Өсгөх боломж байна үү? Нийт хэдэн ажилтан байна? Үндсэн хэдэн ажилтантай вэ? Цаашдаа бүтээгдэхүүний зар сурталчилгаанд үйлдвэрлэл эрхлээд ирвэл мөнгө төсөвлөх нь зүйтэй л дээ. Тэгэхээр жижиг ч байсан хамаагүй үйлдвэрлэл эрхлэх хэрэгтэй. Хаан жимс хэдэн га талбайтай вэ? Хичнээн тн багтаамжтай агуулах барих вэ? 20тн-оор жимс зөөж тээвэрлэх машин монголд байхгүй ш дээ. Хөргөгчтэй чиргүүл байдаг юм үү? Ирээдүйд 5000тн жимс хураах юм бол энэ онд хэдэн тн жимс хураах боломжтой гэж үзэж байгаа вэ? 100тн-ийн агуулах барьж байхаар 200-300тн-ын агуулах барьж болдоггүй юм үү? Үйлдвэр зайлшгүй хэрэгтэй. Экспортийн асуудал яригдаж байгаа юу? Германаас авах санал тавихгүй байна үү?

П.Учрал: Хөрөнгө оруулалтан дээр үйлдвэрийн нийт өртгийг тавиагүй юм үү?

Эндээс харахад цахилгааныг чи яаж хэмжиж байна?

Зар сурталчилгааны зардал гэж юу оруулж өгсөн бэ?

Шар доктороос өөр компанид жимсээ нийлүүлж болдоггүй юм үү?

С.Амгалан: Хөрөнгө оруулалтын задаргаа нь байхгүй юм үү?

100тн жимсийг хэр хугацаанд хадгалах вэ?

Борлуулалтынхаа хэмжээг мэдэж болох үү?

Хадгалах хугацаа хэр удаан хугацаанд үргэлжлэх вэ?

Тийм урт хугацаагаар хадгалдаг юм үү?

Агуулахыг хичнээн хугацааны дараа эргэлтэнд оруулна гэж үзэх вэ?

Шар доктор хэдэн тн жимс авдаг вэ?

С.Амгалан: 2014 оны гүйцэтгэлийг харж байна л даа. Энэ дээр зарим зардлууд нь төсөвлөснөөс хамаагүй хэтрэлттэй байгаа дээр тайлбар хийх хэрэгтэй байна, гүйцэтгэлээ хувиар харуулах хэрэгтэй юм байна, хувьцаат компанийн хувьд төсвөөс хэтэрсэн асуудлуудаа сайн баримтжуулах хэрэгтэй байна.

П.Учрал: Жимс борлуулж байгаа үнээ өсгөхөд ихээхэн асуудалтай нэг компаниас хараат болчихоод байгаа юм. Худалдан авдаг компани зөвхөн Шар доктор, хэрвээ Шар доктор жимс авахгүй гэвэл манай компани жимсээ яах вэ гэдэг асуудалтай байгаа. Тэгэхээр бид энэ дээр үйлдвэрийг оруулж ирээд байгаа юм. Тэгэхээр үйлдвэрийн талаар дараа нь ТУЗ-ийн хурал зарлаж байгаад нарийвчилсан төлөвлөгөөгөө танилцуулах бодолтой байна. 3200 бол хамгийн бага үнэ байгаа. Үндсэн ажилтан 160 гаруй байгаа, туслах ажилтан болон түр ажилчидыг аваад бид 230-250 хүний нөөцтэйгээр 1 жилдээ ажилладаг байгаа. Тэгээд дйээрээс нь онцгой шаардлагаар цэргийн анги, хорихоос хүн нэмж ажиллуулдаг. Бидний тухайн жилдээ хэрэглэдэг, үйлдвэрлэл явуулдаггүй учраас цахилгааны зардал тогтмол дунджаар нь тооцоход бага байдаг. Зар сурталчилгааны 1500 мян.төг ТУЗ-ийн хурал зарлахад л дуусчихаж байгаа. Бид бүтээгдэхүүнээ сурталчлах үүднээс зардал байхгүй. Одоо

Алтанхуягийн үйлдвэр ашиглалтанд орох ёстой, тэр энэ жилдээ ашиглалтанд орох эсэхийг сайн мэдэхгүй байна. Тэдний үйлдвэрт очиж үзээд урьдчилан тохиролцсоноор бол тэдний шугамаар бид бүтээгдэхүүнээ оруулъя, оруулсан бүтээгдэхүүнийхээ зардалд нь буцаагаад түүхий эд өгье гэдэг урьдчилсан тохиролцоо явагдаж байгаа. Тэр үйлдвэрийг үзээд бид тохиролцож чадвал тодорхой хэмжээний бүтээгдэхүүн өөрийн шошготой гаргаад, тэд нараас авах зардалдаа шингээгээд бүтээгдэхүүн өгөх бодолтой байна. Энэ хэлэлцээр эцэслэн шийдэгдээгүй байгаа, үйлдвэр ашиглалтанд орох болоогүй гээд байгаа юм.

Хөрөнгө оруулалтын задаргаа нь Ерөнхий менежерт байгаа, тракторт 490 гаруй сая төг байгаа энд 210 морины хүчтэй 1 трактор, зэрлэг устгагч 170 см, 190 см авцын өргөнтэй 2 ш, 2 ш хор цацагч, тэгээд мод ухагч багтаж байгаа.

Агуулахын зураг авалтан дээр Л.Бямбасүрэн бид 2-ын төлөвлөснөөр 4 гүн хөлдөөгчтэй, дунд нь ариутгалын жимс салгах кабинтайгаар, цаана нь агуулах нь 100тн багтаамжтай хадгалах зоорьтой байх юм. Агуулахыг Солонгосын хөрөнгө оруулалттай авах боломжтой байгаа, хөрөнгө оруулалтаа хийвэл бид тодорхой хугацааны дараа төлөх нь тодорхой.

Шар доктор 500тн-ыг хадгалах агуулахтай. Үйлдвэрийн хэмжээ нь 1000 тн-ых.

Хамгийн багадаа 250тн жимс хураана гэж үзэж байгаа.

Бид 200тн хураачихаад хадгалаад суухгүй, хураагаад тээвэрлээд эргэлтэнд оруулна гэсэн үг. Тийм учраас 100 тн гэж байгаа, 100тн-ийн агуулах 500 тн жимс хураахад хангалттай, 2 сарын хугацаанд л эргэлтэнд орж байна.

Экспортын агуудал үйлдвэрийг барьчихвал тайванаас 3000тн-ийг авъя гэсэн санал байгаа. Германаас авна гэж байгаа.

А.Өлзий-Орших: Шар докторт нийлүүлдэг үнэ. Тавиагүй. Одоогоор 160 гаруй ажилтанд шимтгэл төлж байгаа. Цахилгааныг киловаттаар хэмжиж цахилгааны зардлаа гаргасан.

Л.Бямбасүрэн: Их хэмжээгээр жимс авах тийм компани байхгүй. Их хэмжээгээр авч байгаа газар нь Шар доктор л байгаа. Цэвэр жимсийг худалдаж аваад ундаа хийдэг компани ганцхан Шар Доктор байгаа юм. 80 гаран га талбайтай. Бүгдээрээ очиж үзэх бодолтой байна. 100тн жимсийг 3 сараас илүү хугацаагаар хадгалмааргүй байгаа. 3 сарын дотор ихэнх жимсийг боловсруулаад шингэн хэлбэрт оруулж, дараа нь бүтээгдэхүүн болгож байгаа. Жимсийг хөлдүүгээр нь хамгийн багадаа 24 сар хадгалж болох байх. Битүүмжлэлтэй хөлдөөж хадгалахад 24 сар, гэсгээх юм бол жимсийг хадгалах боломжгүй, задгайгаар нь жимсийг хадгалахад жингийн алдагдалд ордог. Эхлэхдээ 4 хөлдөөх камераас гаргаад жимс тээвэрлэхдээ 4 тн-оор тээвэрлэдэггүйгээр 100 тн-ийн агуулахад хуримтлуулж байгаад 20тн-ийг том машинаар 1 удаа тээвэрлэнэ гэсэн бодолтой байгаа. Тиймээс 100тн-ийн агуулах барих шаардлагатай байгаа. 100тн-ийн хөлдөөх камер энэ жил болон ирэх жил хэрэгтэй цаашдаа хөлдөөх камерыг томруулах хэрэгтэй. Чиргүүл залгаад 20тн-ыг зөөж болно. Хөргөгчтэй чиргүүл байдаг тэгэхдээ хараахан монголд том хэмжээний ачаа зөөх хөргөгчтэй машин байхгүй л дээ. Хэрвээ манай бүх талбайгаас жимс хураагаад эхлэх юм бол 5000тн-оос яригдаж эхлэнэ.

Тэгэхээр бид 4-5 жил хүлээх хэрэгтэй болно

Тийм манай компани шиг их хэмжээгээр тариалж байгаа нөхцөлд үйлдвэр, агуулах хэрэгтэй байна.

Б.Ганбат: Их хэмжээний хэлцэл хийх тухай ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэж батлах байгаа. 2015-02-23 ны өдөр ТУЗ 02/15 гэсэн дугаартай тогтоол гаргасан байгаа, энэ бол их хэмжээний зээл авах, хөрөнгө барьцаалах, гарын үсэг зурах эрх олгох тухай гэсэн тогтоол байгаа. Тогтоолыг уншиж танилцуулав.

Компаний тухай хуулийн дагуу их хэмжээний хэлцэл гэдэг нь тухайн хэлцэл хийхийн өмнөх санхүүгийн тайлан тэнцлийн балансын нийт активийн 20-оос дээш үнийн дүнтэй хэлцлийг хэлдэг. 4 тэрбум гэдэг бол их хэмжээний хэлцэлд тооцогдож байгаа тэгэхээр компанийн тухай хуульд заагдсан журмаа баримтлаад ТУЗ санал нэгтэй энэ шийдвэрийг гаргах ёстой байгаа. Өмнө нь ТУЗ санал нэгтэй шийдвэр гаргасан байгаа, өнөөдрийн хурлаар яагаад энэ шийдвэрийг давхар батлаад байна вэ гэдэг учир шалтгаан нь бол нэгд бид ТУЗ-ийг шинээр сонгосон байгаа цаашид зээлтэй холбоотой ТУЗ-өөс гарах ямарваа нэгэн тогтоол шийдвэрт ТУЗ-өөс гарын үсэг зурах шаардлага гарна. Ийм учраас өнөөдөр өмнөх ТУЗ-ийн шийдвэрийг давхар батлаад өгчихвөл ихээхэн дэмжлэг болно.

Л.Хосбаяр: Зээлийнхээ асуудлыг сайн танилцуул. Яагаад гэвэл компани чинь өөрөө алдагдалтай ажиллаад байна, дээрээс хувьцаа эзэмшигчид бол ашигтай байлгахыг хүснэ, ашигтай байлгаж байж хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хүртэнэ. Тийм болохоор төлөвлөгөөнүүдээ сайн танилцууллаа, 2 жилийн дараа ашигтай ажиллах юм байна тэгэхээр үүнд зориулсан хөрөнгө босгох хэрэгтэй яагаад гэвэл одоо байгаа байдлаараа бол өөрсдөө хөрөнгө босгох боломжгүй байгаа учраас зээл авч байгаа гэдгээ сайн тайлбарлах хэрэгтэй л дээ.

Одоо жижиг хувьцаа эзэмшигчдэд сайн тайлбарлах хэрэгтэй, жишээлбэл 200 га-гийн төсөлд ямар ямар ажил төлөвлөгдсөн юм, үйлдвэрлэлийн барилга, үйлдвэрлэл явуулах зардал багтаж байгаа юм уу?

С.Амгалан: Нэмж хэлэхэд 888 төслөөс их хэмжээний зээл авах гэж байгаа юм бол компаний хувьд 3-5 жилийн төлөвлөгөөгөө боловсруулаад ТУЗ-өөр батлуулах шаардлагатай.

Б.Ганбат: Компаний 888 төсөлд орсон төлөвлөгөө энд байна. Өнөөдрийн хурлаар танилцуулахад ихээхэн цаг хугацаа зарцуулна. Дараа ТУЗ-ийн хурал зарлахад нарийвчилан танилцуулах болно. Энэ төлөвлөгөөг бас ТУЗ-өөр батлавал эрх зүйн талаасаа үр дүнтэй.

Энэхүү зээлийг юунд зарцуулах гээд байна вэ гэвэл:

200 га талбайд чацаргана тариалахад

Усан сан (одоо байгаа усан сангаас 2 дахин том 2400тн багтаамжтай) төсөвт өртөг нь 191сая

П.Учрал: Би тайлбарлая. Энэ 4.5 тэрбум ₮-ийн зээл юунд зарцуулагдах вэ гэвэл шинээр 200 га талбайд чацаргана тариалахад зориулагдана. Бид талбай дээр 2.9 буюу 3 сая суулгацыг борлуулж чадахгүй байж байна. Тэгэхээр бид суулгацаа яах вэ гэхээр өөрсдийн талбай дээр цаашдаа компаний 3000 га талбайд чацаргана тариална. 200га талбайн төсөл дотор хамгийн гол масс авч байгаа нь мод, усалгааны систем юм. Усалгааны системгүй бид цаашдаа ажиллахад хүндрэлтэй. Тэгэхээр бид одоо байгаа 600 га талбайг усалгааны системтэй болгох шаардлагатай. 370 га талбайн усалгааны шугамыг холбосон байгаа, энэ жил ус тавьж үзээд амжилттай болчихвол тэндээ нуурыг байгуулна. Нуурыг байгуулсанаар усны бохирдлын тунгаалтыг хийнэ, тунгаалтыг хийснээр дээрээс нь усыг насосоор соруулж аваад дуслын усалгааны систем тавихад хамгаалах талаасаа хийж байгаа. Дээрээс нь

усалгааны систем тавьсанаар бид ямар давуу талтай вэ гэхээр ургацын хэмжээг тогтворжуулах бүрэн боломжтой, яагаад гэвэл бид модыг хэд услана тэр хэмжээгээр хэдэн кг жимс авах вэ гэдгээ бүрэн тодорхойлох боломжтой.

Усалгааны систем тавьсанаар 1-т ургацын хэмжээг тогтворжуулах, 2-т хүн хүчийг багасгах, өнөөдөр 1 хүн өдөрт 0.5 га талбайг усладаг бол усалгааны системтэй үед тэр хүн өөр ажлаа хийгээд явж байх бүрэн боломжтой. Бид 3-н га талбайд 1 хүн ажиллуулдаг бол 1 хүнд 4 га талбайг хариуцуулах бүрэн боломжтой. Усалгааны систем нь ямар давуу талыг өгч байгаа гэхээр 15-20 жил ашиглах боломжтой гэсэн аман баталгаа өгсөн. Усалгааны систем зарж байгаа компаниуд нь асуудалгүй ажиллах 5 жилийн баталгаа өгнө гэж байгаа. Тэгэхээр энэ 4.5 тэрбум ₮-ийг юунд зарцуулах вэ гэхээр энэ 200 га-г нэмж тариалах, төслийн тооцоон дээр буцаагаад өөрийнхөө өртгөө нөхөх хугацаа нь бол 6.5 жил байгаа. Гэтэл энэ дээр бол эхний тариалсан 600 га талбайн ургацын орлогыг тооцоогүй байгаа, өөрөө өөрийнхөө өртгөө нөхөх хугацаа нь 6.5 жил байдаг. Энэ төслийн мөнгийг бид урьдчилаад төлөх бүрэн боломжтой. Энэ төслийн зээлний төлбөр дээр 600 га талбайн орлого маань дэм болох юм. Тэгэхээр энд усан сан, усалгааны систем, мод, ажиллах хүч /ажиллах хүчний хугацаа маань гурван жил/, 4дэх жилээсээ тухайн төсөл маань өөрөө өөрийнхөө тухайн жилийн өртгийг нөхөн төлөх чадвартай болж байгаа юм. 5, 6 дах жилээсээ үрсгал зардлаа нөхөх боломжтой.

Цаашдаа байгаа суулгацаа ашиглаж байгаад талбайгаа тэлэх хэрэгтэй. Ийм үндэслэлтэй ажиллана. Бидний ирээдүйн зорилго 3000 га талбайд чацаргана тариалах юм. Мод нь бэлэн байхад усалгааны системээ шийдчихвэл бүрэн боломжтой юм. Ийм санхүүжилтыг анх санаачлан 888 зээлд оруулсан. Энэ төсөл маань дэмжигдсэн. Дэлгэрэнгүй задаргаа төсөл дотроо хавсаргасан байгаа. 200 га-ийн төсөл хэрэгжээд цааш нь ахин хэрэгжүүлэх 12 бичил төсөл байгаа. Тэгэж байж 2400 га болоод өмнө нь тариалсан 600 га талбайтай 3000 га талбайтай болох байгаа. Чацарганы маань хувьд нэг хүндрэлтэй тал нь хавар намрын тариалалт байдаг. Хавар намрийн тариалалт маань хязгаарлагдмал хугацаатай байдаг. Бид энэ хугацаанд тарихаас илүү хугацаанд тарьж чадахгүй учраас тариалах тоо хэмжээ бага байгаа юм.

Хурлын дарга П.Бишрэл: За. Ингээд өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудлуудаа та бүхэнд танилцуулж дууслаа. Та бүхний санал шүүмжлэлд компанийн удирдлагын зүгээс хариултуудыг өглөө. Хувьцаа эзэмшигч та бүхэнд өөр тодруулах зүйл, асуулт байна үү? (санал, шүүмжлэл гарсангүй)

Хурлын дарга П.Бишрэл: Ингээд санал хураалтаа эхлүүлье. Та бүхэнд саналын хуудас тараагдсан байгаа.

(Санал хураалт явагдав. Үүний дараагаар хурал 15 минут завсарлав).

Хурлын дарга: Одоо тооллогын комиссоос санал хураалтын дүнг танилцуулна.

Тооллогын комиссын дарга тооллогын комиссын шийдвэр болон тооллогын дүнг уншиж танилцуулав. /Тооллогын дүнг хавсаргав/

Хурлын дарга: За ингээд хувьцаа эзэмшигчидээ хурлаас гарсан тогтоолуудыг Ганбат уншиж танилцуулна.

Тогтоолуудыг уншиж танилцуулав.

Хурлын дарга: Та бүхэнд өөр санал оруулах асуух зүйл байна уу? Ингээд хурлыг өндөрлүүлье. Хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа.

Хурал 17.30-д өндөрлөв.

ХУРЛААР ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компанийн 2014 оны бизнесийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай хэмээн үзэхээр шийдвэрлэв.
2. Компанийн 2014 оны жилийн санхүүгийн тайлангийн тухай ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хангалттай хэмээн үзэхээр шийдвэрлэв.
3. 2014 оны жилийн санхүүгийн тайлангийн дагуу 110,057.08 мянган төгрөгийн алдагдалтай ажилласантай холбогдуулан 2014 онд ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг зөвшөөрөв.
4. Нэг. "Хархорин" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр Б.Бүрэн, С.Амгалан, Д.Баярмаа нарыг, "Хархорин" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр П.Учрал, П.Бишрэл, О.Төмөрбаатар, Л.Хосбаяр, Ж.Энхтөр, Ц.Энх-Амгалан нарыг тус тус батлав.
5. Компанийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлав.
6. Экспортыг дэмжих, импортыг орлох 888 төслийн хүрээнд "Хархорин" ХК-ийн 200 га талбайд чацарганы аж ахуй байгуулах төслийг санхүүжүүлэх зориулалтаар банк, санхүүгийн байгууллагаас нийт 4,039,900,000 төгрөгийн хөнгөлөлттэй зээл авах, тус зээлийн барьцаанд компанийн өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгө, газар эзэмших эрх болон үйл ажиллагааны орлогыг барьцаалахтай холбоотойгоор их хэмжээний хэлцэл байгуулахыг шинээр байгуулагдсан Төлөөлөн Удирдах Зөвлөлд зөвшөөрөв.

ХУРЛЫН ДАРГА



П. БИШРЭЛ